

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

№	Дугаар	Шийдвэрийн нэр, огноо, агуулга	Биелэлт	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ: 1					
1. Монгол Улсын хууль					
1.1		Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2023.07.07	Тус байгууллагын ажилтан, албан хаагчид нь иргэд, даатгуулагч болон ажил олгогчдод Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ 2024 оноос хэрэгжиж эхэлсэн нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах, нийгмийн даатгалын ач холбогдлыг өргөн хүрээнд ойлгуулах чиглэлээр төлөвлөгөөтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.		
1.2		Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль 2023.07.07	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийг хэрэгжүүлэн, ажил олгогч, даатгуулагч иргэдэд сурталчлан ажиллахаас гадна 2024 оны дунджаар 24207 тэтгэвэр авагчдад нийт 241,3 тэрбум төгрөг, 2025 онд дунджаар 25100 тэтгэвэр авагчдад нийт 23,05 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгосон байна.		
1.3		Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль	Тус газар нь 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай		

		2023.07.07	хуульд зааснаар нийт 20003 даатгуулагчдад 26.4 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна. . Үүнд: - Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 15016 даатгуулагчдад 4,8 тэрбум төгрөг - Жирэмсэн амаржсаны тэтгэмжид 1889 даатгуулагчдад 8,3 тэрбум төгрөг - Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжид 578 даатгуулагчдад 1,1 сая төгрөг - Ажилгүйдлийн тэтгэмжид 2150 даатгуулагчдад 10,3 тэрбум төгрөг		
1.4		Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль 2023.07.07	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэн, ажил олгогч, даатгуулагч иргэдэд сурталчлан ажиллахаас гадна тус хуулийн хүрээнд 2025 онд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 232 даатгуулагчдад 4,7 сая төгрөгийн тэтгэмж, төлбөр бодож олгосон байна.		
Хэсгийн дундаж 100 хувь					
2. Засгийн газрын тогтоол					
2.1	№75	Аргачлал батлах тухай 2024.09.11	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.1-д “Тэтгэврийн авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан жил бүрийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын аргачлал батлах тухай 75 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тус дүүргийн 24422 тэтгэвэр авагчийн тэтгэврийг батлагдсан аргачлалын дагуу нэмж, 2024 оны 12 сард 20,8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож байсан бол 2025 оны 01 дүгээр сард 22,66 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож тэтгэврийн хэмжээг 1,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.		

2.2	№221	Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024.12.18	Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 221-р тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, тус дүүргийн 24422 тэтгэвэр авагчийн тэтгэврийг батлагдсан аргачлалын дагуу нэмж, 2024 оны 12 сард 20,8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож байсан бол 2025 оны 01 дүгээр сараас 22,66 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож тэтгэврийн хэмжээг 6 хувиар буюу 1,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон. Хувь тэнцүү тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэн 572400 төгрөгийн тэтгэврийг 3406, бүрэн тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэн 689000 төгрөгийн тэтгэврийг 6630 тэтгэвэр авагчид олгосон.		
2.3	№2	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь хэмжээг тогтоох тухай 2025.01.02	Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2025 оны төсвийн хуваарийн дагуу 184,1 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2025 оны жилийн эцсийн байдлаар 119,9 тэрбум төгрөг төвлөрүүлэн ажилласан байна.		
2.4	№109	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025.02.26	Монгол үндэстний уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан гаргасан шийдвэрийн дагуу 2025 оны 3 дугаар сарын 3, 4, 5-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарагт ажилтан, албан хаагчдыг амраасан. Үүнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын тушаалын дагуу дээрх амралтын өдрүүдийг нөхөн ажиллуулах зохицуулалтаар ажилтан, албан хаагчид, нөхөн ажилласан болно.		
2.5	№23	Архивын улсын үзлэг зохион байгуулах тухай 2025.07.09	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан 3Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын удирдамж”-ийн дагуу тус газар нь хамрагдаж, “ Хангалттай ” гэж үнэлүүлсэн. Үзлэгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, баримт бичгийн хадгалалт, цахимжуулалт, бүртгэлийн үе шаттай		

			сайжруулах арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд 2026 оны газрын төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөж байна.		
2.6	№147	Томуу, томуу төст өвчний дэглэмийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025.10.29	Томуу, томуу төст өвчний дэглэмийн үед 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тус газрын 6 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагч 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох шийдвэрийг дагаж мөрдөн ажиллаж байгаа. Тогтоолын дагуу ажилтан, албан хаагчдаас чөлөө, хүсэлт ирээгүй байна.		
Хэсгийн дундаж 100 хувь					
3. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны тогтоол					
3.1	№3	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024.10.07	2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792 000 төгрөг болгон шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан болон түүнтэй холбоотой тооцоололд өөрчлөлтүүд орсон. Мөн сайн дурын нийгмийн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ шинэчлэгдэж, холбогдох даатгуулагчдын гэрээ шинэчлэн байгуулсан болно.		
Хэсгийн дундаж 100 хувь					
4. Монгол улсын засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс					
4.1	№11	Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг олон нийтэд ил тод, нээлттэй болгох тухай тэмдэглэл 2025.08.06	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлээр Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг нийтэд ил, тод нээлттэй болгох арга хэмжээ авахыг даалгасны дагуу тус газрын ажилтан, албан хаагчдын 2024 оны энхий хагас жил, жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээний хуудсыг байгууллагын цахим хуудсанд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байршуулсан болно.		

Хэсгийн дундаж 100 хувь					
5. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол					
5.1	№8	Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай 2023.12.04	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 2 сая төгрөг болгон нэмэгдүүлж 2025 онд 578 иргэнд 1,156.0 сая төгрөг олгосон.		
5.2	№10	Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай 2023.12.04	Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг нэг ор хоногт 70,000 төгрөг болгосонтой холбогдуулан 2024 онд 13 иргэнд 2,1 сая төгрөг, 2025 онд 1 иргэнд 360,0 мянган төгрөг тус тус олгосон.		
5.3	№20	Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай 2023.12.21	Тогтоолын дагуу 2025 онд 1 даатгуулагчид нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоон сард 2680120 төгрөгийн тэтгэвэр олгож байна.		
5.4	№10	Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай 2025.07.23	Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу даатгуулагчийн тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.34 хувиар тогтоосныг дагаж мөрдөн ажиллаж байна.		
Хэсгийн дундаж 100 хувь					
6. Батлан хамгаалахын сайд, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал					
6.1	№А/95/81	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар 2025.04.02	БХС, ГБХНХС-ын хамтарсан 2025 оны 04 дүгээр сарын 12-ны №А/95/81 тоот захирамжаар “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар” хэрэгжүүлэн ажиллаж, 2025 онд Цэргийн алба хаасны тэтгэврийг 1390 иргэнд 3,5 тэрбум төгрөг, цэргийн тэжээгчээ		

			алдсаны тэтгэврийг 53 иргэнд 43,0 сая төгрөг, цэргийн хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэврийг 9 иргэнд 65 сая төгрөг тус тус олгосон байна.		
Хэсгийн дундаж 100 хувь					
7. Улсын ерөнхий прокурор, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал					
7.1	№А/42, А/71	Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал 2024.03.13	Улсын ерөнхий прокурор, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал”-ын дагуу эрх бүхий албан тушаалтны оногдуулсан шийдвэрийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор сайн дураар биелүүлэх үүрэгтэй байх зохицуулалттай. Аргачлалын дагуу торгох шийтгэлийн хэмжээг хугацаа хэтрүүлсэн хүн, хуулийн этгээдэд сар бүр 10 хувиар нэмэгдүүлэн тооцохоор заасан байна. Тус газарт хэрэгжүүлж буй эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг биелүүлээгүй тохиолдол гараагүй байна.		
Хэсгийн дундаж 100 хувь					
8. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар					
8.1		2 ба түүнээс дээш тэжээгчээ алдсан тэтгэврийн бүтээгдэхүүний нийлбэр цалинг хэрхэн тооцоолох тогтоолт хийх заавар 2025.06.01	Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг олгож байгаа бөгөөд тус газарт 2 ба түүнээс дээш тэжээгчээ алдсан тэтгэвэр тогтоолтын хүсэлт ирээгүй болно.		
Хэсгийн дундаж 100 хувь					
9. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал					
9.1	№А/169	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчид харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай “Мэдэгдэл”-ийн загвар,	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчид харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай “Мэдэгдэл”-ийн загвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах уулзалтын тэмдэглэл”-ийн загвар, “Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ”-ний загвар, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуваарь загварын дагуу хамралт,		

		Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах уулзалтын тэмдэглэл"-ийн загвар, "Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ"-ний загвар, "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуваарь" маягтын загвар батлах тухай 2024.10.03	орлогын хэлтсийн улсын байцаагч нар үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн өр үүсгэсэн аж ахуй нэгж байгууллагын удирдлагатай уулзалт зохион байгуулж "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын дагуу шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж сар бүрийн 1,15-ны өдрүүдэд Шимтгэл хураалт удирдлага арга зүйн газарт мэдээ тайланг хүргүүлж ажиллаж байна. Тухайн маягтын дагуу дараах арга хэмжээг авсан болно. <u>Албан шаардлага</u> - 239 ААНБ-ын 15,518.4 сая төгрөгийн авлагад шаардлага хүргүүлснээр 80 ААНБ-ын 460,3 сая төгрөгийн авлага барагдуулсан. <u>Данс хаасан</u> – 2494 ААНБ-ын 45,013,7 сая төгрөгийн авлагатай холбоотойгоор байгууллагын харилцах данс хааснаар 372 ААНБ-ын 8,448.5 сая төгрөгийн авлагыг бууруулан ажиллаж байна. <u>Уулзалт</u> – 87 ААНБ-ын 8,121.6 сая төгрөгийн өр авлагыг талаар уулзалт хийж 22 ААНБ-ын 314,0 сая төгрөгийг барагдуулж цаашид өр авлага үүсгэхгүй ажиллах талаар зөвлөгөө мэдээлэл өгөв. <u>Гэрээ байгуулан</u>-267 ААНБ-тай 41,794.8 сая төгрөгийн авлага барагдуулах гэрээ байгуулснаас 267 ААНБ-ууд 12,263.5 сая төгрөгийг санд төлж гэрээний биелэлтээ ханган ажиллаж байна.		
9.2	№А/37	Шилдэг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах тухай 2025.02.18	НДЕГ-ын даргын 2025.02.18-ны №А/37 тоот Шилдэг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах тухай тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж, тухай бүр хийсэн ажлын тайланг НДЕГ-ын ЭММТЗ-д хүргүүлсэн. НДЕГ-ын дэргэдэх ЭММТЗ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн		

			магадлалын зөвлөлүүдийн эмч гишүүд, нарийн бичгийн дарга нарыг оролцуулж, 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 15.00-18.30 цагийн хооронд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын хурлын танхимд ижил мэргэжилтний үзлэг хийх ажлыг зохион байгуулсан. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа хэлэлцсэн 1542 иргэний онош баталгаажуулсан шинжилгээний хариу, амбулаторийн картын бичилт, дүгнэлт зэргийг шалгаж 801 иргэний бичиг баримт шинжилгээг сканердаж, мэдээллийн сан үүсгэн хадгалж байна.		
9.3	№А/38	2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарлах тухай 2025.02.19	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласан бөгөөд энэ ажлын хүрээнд тус газарт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хуримтлагдсан авлагын хэмжээ насжилтыг тодорхойлсон судалгааг гарган “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын А/199 дүгээр журмын дагуу шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байна.Үүнд: -5,698,5 сая төгрөгийн хуримтлагдсан шимтгэлийн өртэй 239 ажил олгогчид Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. -45,013.7 сая төгрөгийн өртэй 2,494 ажил олгогчийн арилжааны банкн дахь харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 295 ажил олгогчийн 4,152,5 сая төгрөгийн шимтгэлийн өрийг төлүүлсэн. -41,655.7 сая төгрөгийн өртэй 265 ажил олгогчтой авлага барагдуулах гэрээг байгуулахдаа 3,805 сая төгрөгийг урьдчилан төлүүлж гэрээ байгуулсан. -3 аж ахуй нэгжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шилжүүлж ажилласан. Бид даатгуулагчдыг дэмжих ажлын хүрээнд ажил олгогчдын зөвлөгөө хоёр удаа зохион байгуулж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн		

			даатгуулагч, ажилтнуудын нийгмийн баталгааг ханган, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нийгмийн хариуцлагыг нь үнэлж “Шилдэг ажил олгогч”-оор 9 аж ахуйн нэгжийг өргөмжлөх, өөрийн цахим хуудсанд сурталчлан таниулах		
9.4	№А/47	Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө батлах тухай 2025.02.28	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө батлах тухай” А/47 дугаар тушаалын хавсралтад тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилт, үр дүн, ажлын явцыг нэгтгэн, Нийгмийн даатгалын ерөнхий газарт улирал бүр тайлагнан ажилласан.		
9.5	№А/68	Хяналт-шинжилгээний ажил зохион байгуулах тухай 2025.03.21	Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын төсвийн шууд захирагчийн 2024 онд гаргасан захиргааны акт болох А, Б тушаалын хууль зүйн үндэслэлийг шалгаж, дүгнэлт, зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тус газрын А 49, Б 120, нийт 169 тушаалыг хавсралтын хамт сканердан Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж ажилласан.		
9.6	№А/98	Сургалт зохион байгуулах тухай 2025.04.23	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдөр зохион байгуулах “Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах” сургалтын хөтөлбөрийн дагуу тус газрын 3 албан хаагч хамрагдаж Нийгмийн даатгалын мэдээллийн “Sicos” системийн “Сургагч багш” бэлтгэх сургалтад хамрагдаж СЕРТИФИКАТ гардаж авсан.		

9.7	№А/132	Сургалт зохион байгуулах тухай (Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг танилцуулах) 2025.05.08	Улсын ерөнхий прокурорын газраас 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-г танилцуулах сургалтыг УПЕГ-ын хяналтын прокурор, сургагч багш Б.Соёлсайхан, М.Энхтунгалаг, “Ай Ти Зон” ХХК-ний программист А.Буяндэлгэр нарын сургалтад тус газрын 12 байцаагч, албан хаагчид бүрэн хамрагдсан.		
9.8	№А/197	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын менежментийн төлөвлөгөө батлах тухай 2025.07.09	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/197 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын менежментийн төлөвлөгөө”-д тусгагдсан холбогдох нийт 12 арга хэмжээний үр дүн, биелэлтийг нэгтгэн гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газарт хүргүүлж ажилласан болно.		
9.9	№А/244	“Итгэлцлийн аян”-ыг зохион байгуулах тухай 2025.09.12	2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг дуусталх хугацаанд Итгэлцлийн аяны зохион байгууллаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өртэй 125 ажил олгогчийн 620 гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэн нарт аяны танилцуулга, мэдээ мэдээллийг өгсөн. Энэ хугацаанд 18 ажил олгогчийн арилжааны банк дахь харилцах дансны зарлагын гүйлгээг аяны хугацаанаас өмнө хаасан ажил олгогчийг дансыг шимтгэлийн 10 хувийг төлүүлэн нээж өгсөн. 398,7 сая төгрөгийн авлагаас 201,1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өртэй 67 ажил олгогчийн гүйцэтгэх удирдлагатай уулзалт зохион байгуулж, шимтгэлийн өрийн дүнгээс 10 хувиас багагүй хэмжээгээр төлсөн 13,3 тэрбум төгрөгийн төлбөр зөрчлөөс 1,1 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг төлүүлж 6 сар хүртэлх хугацаатай өр төлөх нарийвчилсан хуваарь, тэмдэглэл, гэрээ үйлдэж		

			баталгаажуулсан. Хуримтлагдсан шимтгэлийн өртэй 77 ажил олгогчийн 2,3 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагыг төлүүлж ажиллаа.		
9.10	A/267	Тэтгэмж бодох заавах батлах тухай 2025.10.10	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн A/267 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Тэтгэмж бодох зааврын дагуу жирэмсэн амаржсаны, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг нийгмийн багц хуулийн хүрээнд хугацаанд нь бодож олгон ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 20836 иргэнд 25,5 тэрбум төгрөгийн тэтгэмжийг бодож олгосон байна.		
9.11	A/303	Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулахтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал, шалгалтад бэлтгэх сургалтын хөтөлбөр хүргүүлэх тухай 2025.11.05	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, сэргээх, баталгаажуулах шалгалтыг зохион байгуулахтай холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын A/303 тушаалаар батлагдсан шалгалтад бэлтгэх 2025 оны 11 дүгээр сарын 12-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хөтөлбөрийн дагуу шалгалтад хамрагдах нийт 18 албан хаагчдыг ажлаас чөлөөлөх ажлыг зохион байгуулж хамруулсан болно.		
9.12	A/334	Нийгмийн даатгалын салбарт хамтран ажиллах хэлэлцээртэй орнуудын гадаадын иргэнд өндөр насны тэтгэвэр тогтооход	Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээртэй орнуудын гадаадын иргэнд өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах зааврын дагуу хэлэлцээрт улсын иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилласан хугацааг тооцох, тэтгэвэр бодох, тогтоох олгох, хувийн хэрэг бүрдүүлэх, хадгалах, хяналт тавих,		

		баримтлах заавар батлах тухай 2025.11.28	тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн тусгай зохицуулалтыг тус газрын Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн ажилтан, албан хаагчдад танилцуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацаанд хэлэлцээрт улсын гадаадын иргэдийн тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирээгүй болно.		
10. Монгол улсын Ерөнхий сайдын албан даалгавар					
10.1	№4	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025.07.25	Ерөнхий сайдын албан даалгавыг хэрэгжүүлэх Нийгмийн даатгалын ерөнхий газрын баталсан төлөвлөгөөнд тусгагдсан 5 арга хэмжээний биелэлтийг гарган 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, 12 дугаар сарын 10-ны өдөр албан бичгийн хавсралтаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн болно.		
11. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар					
11.1	№1	Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай 2025.03.14	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” №1 албан даалгаврын арга хэмжээний биелэлтийн хагас жилээр болон бүтэн жилээр тус тус гарган Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.		
12. Зөвлөмж, чиглэл, заавар					
12.1	№01/47	Зөвлөмж хүргүүлэх тухай 2025.01.07	НДЕГ-ын “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 онд баримтлах зааврыг байцаагч ажилтнуудад танилцуулан, өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: - 2025 онд дунджаар тэтгэврийн даатгалын сангаас 24898 тэтгэвэр авагчид 281,5 тэрбум төгрөг, Зарим иргэдийн тэтгэврийн нэмэгдэлд 1274 тэтгэвэр авагчид 63,7 сая төгрөг, Тэтгэврийн тусгай зохицуулалтаар 279 тэтгэвэр авагчид 392,5 сая төгрөг цэргийн албан хаагчийн тэтгэвэрт 1397 тэтгэвэр авагчид 22,9 тэрбум төгрөг,		

			YOMШӨ-ий даатгалын сангаас 138 тэтгэвэр авагчид 1,1 тэрбум төгрөг, нийт 27986 тэтгэвэр авагчид 306,5 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна. 2025 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд зааснаар нийт 19378 даатгуулагчдад 26.1 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна.		
12.2	№12	Чиглэл хүргүүлэх тухай 2025.01.23	Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл ажиллагааг тэгш, хүртээмжтэй үзүүлэх эмч, мэргэжилтнүүдийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үйл ажиллагааны хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтад тус зөвлөлийн дарга, 8 гишүүн танхимаар, 1 эмч цахимаар хамрагдсан. Мөн чиглэлийн дагуу гишүүдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнд Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хязгаарлалт тогтоосноос бусад аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига, ашиг сонирхлын зөрчлийн ангид байх тухай тусган, гишүүд мөрдөн ажиллаж байна.		
12.3	№02/259	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах тухай 2025.02.05	Байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудас, www.shilen.gov.mn сайтад заасан 5 төрлийн нийт 68 мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулсан.		
12.4	№01/746	Хуулийн хэрэгжилтийг хангах тухай 2025.03.31	Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын болон хэлтсийн дарга нар нь тусгайлан олгогдсон эрхийн шатлал буюу статус өөр төрийн байгууллагуудтай Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйл, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай		

			хуулийн 8 дугаар зүйлд зааснаар агентлагийн дарга Монгол улсын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын нэгжийн даргатай, хуульд өөрөөр заагаагүй бол бусад яам, агентлагтай шууд харилцана. Харин аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь Сайд, Засгийн газрын гишүүн, яам, агентлаг, дээд шатны төрийн бусад байгууллагатай захиргааны удирдлагын шатлалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газраар дамжуулан харилцаж байгаа болно.		
12.5		Архив, албан хэрэг хөтлөлтийн зөвлөмж 2025.04.29	Тус зөвлөмжид тусгагдсан Архивт албан баримт хүлээлгэн өгөх, Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны, захирамжлалын баримт бичгийн бичвэр, Баримт бичгийн шийдвэрлэх хугацаа, Явуулах албан бичигтэй ажиллах, Бичвэр, Монгол бичгийн бичвэр, Хавсралтын тухай тэмдэглэлтэй тус газрын ажилтан, албан хаагчид судлан танилцан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн №214 дүгээр тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлд зааснаар байгууллагын албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж, үйл ажиллагааны онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг батлахаар төслийг боловсруулж байгаа болно.		
12.6	№04/1091	Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд холбогдох хууль, журам, дүрэм, зааврыг үндэслэн зөвлөмж хүргүүлэх тухай 2025.05.02	Зөвлөмжид дурдсан Малын тооллогын бүртгэл “А” дансны талаар, “Түгээгч”, “Галч” ажил мэргэжлийг хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд хамааруулах талаар, Төрийн албан хаагчийн давхар ажил эрхлэлтийн талаарх тус зөвлөмжийг ажилтнуудад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны хагас жилд дээрх 3 нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч байхгүй болно.		

12.7	№01/1094	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улстай “Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, ОХУ-ын иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох ажлыг шуурхай зохион байгуулах зөвлөмж хүргүүлэх тухай 2025.05.02	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улстай “Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, ОХУ-ын иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох ажлыг шуурхай зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, Сикос системд тэтгэврийн тогтоолт хийхэд YUD болон ЮД-регистртэй тэтгэвэр авагчдыг хайж олох, F-12 оронтой регистрээр солих ажлыг шуурхай зохион байгуулан, МТТ болон банкуудад мэдээлэл хүргүүлэн ОХУ-ын 3 иргэний тэтгэврийг сар бүрийн 1-нд эх файлаар олгодог болсон.		
12.8	№06/1177	Нийгмийн даатгалын байгууллагад холбогдох гүйцэтгэх баримт бичгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг хүргүүлэх тухай 2025.05.12	Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан Нийгмийн даатгалын байгууллагад холбогдох гүйцэтгэх баримт бичгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд тус газарт 2024 онд шүүхийн шийдвэр гарсан 5194,3 сая төгрөгийн өртэй 3 аж ахуйн нэгжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шилжүүлж ажилласан.		
12.9	№04/1360	Зөвлөмж хүргүүлэх тухай 2025.06.02	БХС, ГБХНХС-ын хамтарсан 2025 оны 04 дүгээр сарын 12-ны №А/95/81 тоот захирамжаар “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар” хэрэгжүүлэн ажиллаж, 2025 онд Цэргийн алба хаасны тэтгэврийг 1390 иргэнд 3,5 тэрбум төгрөг, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг 53 иргэнд 43,0 сая төгрөг, цэргийн хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэврийг 9 иргэнд 65 сая төгрөг тус тус олгосон байна.		
12.10	№01/1721	Чиглэл хүргүүлэх тухай /ҮОМШӨ сувилал/ 2025.07.09	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийг тус газрын Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн тэтгэмжийн байцаагчид танилцуулан үйл		

			ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. “Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам”-ын дагуу сонгон шалгаруулалтад шалгарсан нэр бүхий сувилалд эмчлүүлсэн даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг авах хүсэлт тус газарт ирээгүй болно.		
12.11	№01/2065	Чиглэл хүргүүлэх тухай /Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах/ 2025.09.05	Тус газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн баталсан нийгмийн даатгалын нөхөн тайлантай холбоотойгоор 2024-2025 оны нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн тайлагнасан зөрчилтэй байх магадлалтай 211 аж ахуйн нэгжийн тайланг шалгаж ажилласан. Шалгалтаар илэрсэн зөрчлийн мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хуулийн байгууллагад хүргүүлж ажилласан.		
12.12	№03/2105	Зөвлөмж мэдээлэл хүргүүлэх тухай /Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2/ 2025.09.10	Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ крилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэж заасны дагуу албан хэргийг хос бичгээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөтөлж байна гэж заасны дагуу Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 113 тоот албан бичгийн хоёрдугаар хавсралтын зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжүүлэн ажиллаж байна.		
12.13	№08/2666	Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйл “Торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэл”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж, шийдвэрийг хүргүүлэх тухай	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн дагуу Торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлсэн 5-н аж ахуйн нэгж байгууллагын 8 сая төгрөгийн торгуулийн шийтгэлээс 50 хувь буюу 4 сая төгрөгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн №28/2666 тоот шийдвэрийн хөнгөрүүлж шийдвэрлэсэн.		

		2025.10.17			
12.14	04/3110	Зөвлөмж хүргүүлэх тухай 2025.11.27	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд төрийн албан хаагчаас бусад тэтгэвэр тогтоолгох даатгуулагч давхар ажил хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд тэтгэвэр бодох цалин хөлсөнд өөрчлөлт орохгүй тохиолдолд ажил олгогчийн тайланд өөрчлөлт оруулахгүй байх зөвлөмжийг судлан, байцаагч, ажилтнуудад танилцуулан, хэрэгжилтийг ханган хяналт тавьж байгаа болно.		
Хэсгийн дундаж: 100 хувь					
Нийт дундаж: 100 хувь					

ХЯНАЖ ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА

Б.ЭНХТӨР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.БАЯРХҮҮ

---oOo---